



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР



# Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ



2023 оны 11 дүгээр сарын байдлаар

Мөрөн сум

## ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар 2029 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 60 тохиолдол буюу 2,9%-иар буурсан байна. Төрөлт Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Ханх, Цагаан-Уул, Цагааннуур сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 80.0% байна.




### ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт 2040 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 56 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3.0 хувь /61/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 97,0 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2023 оны эхний 11 сард нийт 53663 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 23.3 хувь нь А амин дэм, 58.0 хувь нь Д амин дэм, 5.5 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

## НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдсэн нь 2022 оны мөн үеэс 17 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 8.3 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 41.2 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 3.4 байна. Нийт 12 тохиолдол буюу 70.6 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 8 нь эрэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



## 1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2023 оны эхний 11 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор өссөн байна. 1000 амьд төрөлтөнд 6.4 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл хавдар 2, мэдрэлийн тогтолцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 3, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 1, төрөлхийн гаж хөгжил 2, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 4 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

### 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, бодит тоогоор




### 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 2023 оны эхний 11 сарын байдлаар



## НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ


2023 оны эхний 11 сарын байдлаар 669 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 43 тохиолдолоор буурсан байна. Нийт нас баралтын 18,5 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 38,7 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 74 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 40 тохиолдолоор буурсан, нийт нас баралтын 11,1 хувийг эзэлж, 10000 хүн амд 5,4 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 197 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 18 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 29,4 хувийг эзэлж, 10000 хүн амд 14,3 ногдож байна.

### Нас баралтын мэдээлэл, 2023 оны эхний 11 сарын байдлаар



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/


1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 21.8
2. Хавдар-14.3
3. Гадны шалтгаант өвчлөл- 5.4
4. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-2,0
5. Амьсгалын тогтолцооны өвчин-1.7




Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 1137, эсийн шинжилгээ 6156 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 78 нас баралт буюу 44.9% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 43 тохиолдол байна.

### АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар амбулаторид нийт 543387 үзлэг хийгдсэнээс 39.0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 49.4 хувийг өвчний учир амбулаторид, 4.4 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 5.3 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 1.9 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.




### Амбулаторийн үзлэг, 2022-2023 оны эхний 11 сарын байдлаар



### ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 1818 жирэмсэн эмэгтэйчүүдээс 92,8 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 96,1 хувь нь хамрагдаж, 1.5 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 11 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 91.8 хувийг, тэмбүү болон ХДХВ илрүүлэх шинжилгээнд 95.1 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-30 трихомониаз-9, тэмбүү-15 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.

### Жирэмсэний эрт хяналтын хувь, 2023 оны эхний 11 сарын байдлаар



### ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2023 оны эхний 11 сарын байдлаар халдварт бус өвчлөл 130235 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 12630 тохиолдлоор өссөн байна. 10000 хүн амд 9451.1 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1413 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.1 хувийг эзэлж, 10000 хүн амд 102.5 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/



1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 2000.0
2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1972.7
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-1744.9
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-977.9
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-771.5



Стационарт нийт 27404 хүн хэвтэж эмчлүүлж, 183032 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.7, орны эргэлт 29.2, орны фонд ашиглалт 195.1 фонд ашиглалтын хувь 64.5 байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт 16721 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 16.5 хувь /2765/ нь алсын дуудлага, 3.8 хувь /637/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 50.7 дуудлага, АНЭ 16.2 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

### ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний 11 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 54801 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 62.5 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 43.2% эрэгтэй, 56.8% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 6385 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 513 буюу 8.0% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 40340 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 76.2 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 42.0% эрэгтэй, 58.0% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1905 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 32 буюу 1.7% нь онош баталгаажсан байна.





## ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 110156 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 54.5 хувь
- Өвчний учир үзлэг 23.6 хувь
- Диспансерийн хяналт 7.2 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 14.1 хувь
- Гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 13120 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 6.5 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 656 жирэмсэн эмэгтэйдгээс 91.8 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 205 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 37 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 71, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 2 тохиолдол бүртгэгдсэн байна.



## **ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Хувийн эмнэлгүүд нийт 31226 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 14.0 хувь
- Диспансерийн хяналт 2.6 хувь
- Өвчний учир үзлэг 83.4 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 7450 хүн хэвтэн эмчлэгдэж, 53748 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 24.2 ба орны фонд ашиглалт 174.5, орны фонд ашиглалтын хувь 57.7 байна.

Нийт халдварт бус өвчний 54 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 40 тохиолдол бүртгэгдсэн байна.

## **ХАЛДВАРТ ӨВЧИН**

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 1146 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 83,2 ногдож байна. 2022 оны мөн үед 5494 тохиолдол, 10000 хүн амд 401,5 ногдож байжээ.

10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Алаг-Эрдэнэ /134.8/, Тосонцэнгэл /147.3/, Төмөрбулаг /88.3/, Цагаан-Үүр /104.0/, Мөрөн /141.2/ суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 59,9 хувь, сүрьеэ 5.8 хувь, амьсгалын замын өвчин 17,1 хувь, цусан халдвар 0.8 хувь, гэдэсний халдварт өвчин 10.8, арьс салтстаар халдварлах халдвар 0,9, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0,7 хувь, Ковид-19 халдвар 4,0 хувийг тус тус эзэлж байна.

## **ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН**

Нийт цочмог халдварт өвчний 460 тохиолдлоос:

- Сальмонеллэз 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит А 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастронтерит ба суулга 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 7 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Ковид-19 46 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4255 тохиолдлоор тус тус буурч
- Сүрьеэ 66 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Цусан суулга 62 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 34 тохиолдлоор
- Хоолны хордлого 59 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 50 тохиолдлоор
- Хачигт энцефалит 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ёлом 11 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор
- Салхинцэцэг 169 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 103 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 22 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 16 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор тус тус өсч
- Хепатит С 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үетэй адил тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахаруу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.

Цочмог халдварт өвчин, бодит тоогоор  
2023 оны эхний 11 сарын байдлаар


	1	62	59	2	6	3	66	11	169	1	7	22	5	46	
	Сальмонеллез	Цусан суулга	Хүнснэс гаралтай бактер хордлого	Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга	Халдварт гепатит А	Халдварт гепатит В	Халдварт гепатит С	Сүрьеэ	Ёлом	Салхин цэцэг	Хачигт энцефалит	Хачигт рикеттиоз	Гар хөл амны өвчин	Улаан-Эсэргэнэ	Ковид-19
■ 2022	2	28	9	5	1	4	3	64	3	66		16	6		4301
■ 2023	1	62	59	2		6	3	66	11	169	1	7	22	5	46

■ 2022 ■ 2023


**ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ**

- 2023 оны эхний 11 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 372 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 17.2 хувь (64), цэврүүт тууралт 49.2 хувь (183), цочмог халууралт, цусархаг тууралтат 14.0 хувь (52), цочмог шарлалттай 2,2 хувь (8), цочмог усархаг 1.6 хувь (6), суулгалт хоолны хордлогот халдвар 15,9 хувь (59) тус тус бүртгэгдсэн байна.
- Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/


Халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдол,  
харьяалалаараа




### Халдварт өвчний хамшинж, сэжигтэй нийт тохиолдол, бүртгэгдсэн долоо хоногоор




### Халдварт өвчний хамшинж сэжигтэй өвөрмөц тохиолдол бүтцээр, 47-р долоо хоногийн байдлаар



### Тууралттай хамшинжийн тохиолдол мэдээлэгдсэн долоо хоногоор




### Суулгалттай хамшинжийн тохиолдол мэдээлэгдсэн долоо хоногоор




### ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2023 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 24948 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1810,5 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 24960 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1824,0 болсон байна.


### Томуу, томуу төст өвчин, 10 000 хүн амд




### Томуу томуу төст өвчин, долоо хоногоор



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)



АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар), 2022 он




## БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН


Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 59,9% (686) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 17.9% (986) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Гोनкоккт халдвар 522 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 255 тохиолдлоор
- Трихомониаз 45 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор
- Тэмбүү 119 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 26 тохиолдлоор тус тус буурсан байна.


Бэлгийн замын халдварт өвчин, 2023 оны эхний 11 сарын байдлаар



Бэлгийн замын халдварт өвчин, насны бүлгээр



Бэлгийн замын халдварт өвчин, боловсролын түвшингээр



ХЯНАСАН:

ДУГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХ-АЮУШ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА